



СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Судалгааны ажлын сэдэв: Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцааны үнэлгээ

Монголбанкны үйл ажиллагааны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцааг үнэлэх судалгааны ажлыг гүйцэтгэх судалгааны баг, байгууллагыг тус судалгааг гүйцэтгэх сонирхол, холбогдох материалаа ирүүлэхийг урьж байна. Тус судалгаа нь дараах зорилготой:

- Монголбанкны чиг үүрэг, хэрэгжүүлж буй бодлогын талаар олон нийт (цаашид энэхүү судалгаанд хамрагдагч гэх) хангалттай мэдлэг, мэдээлэлтэй байдаг эсэхийг үнэлэх;
- Судалгаанд хамрагдагчидын Монголбанкинд итгэж буй итгэлийг үнэлэх;
- Монголбанкны үйл ажиллагааны ил тод байдлыг судалгаанд хамрагдагчид хэрхэн үнэлдгийг тодорхойлох;
- Монголбанкны мэдээллийн нээлттэй байдлыг судалгаанд хамрагдагчид хэрхэн үнэлдгийг мэдэх;
- Монголбанкны олон нийттэй харилцах харилцааг судалгаанд хамрагдагчид хэрхэн үнэлж байгааг судлах.

Судалгааны ажлын хамрах хүрээ, бүрдүүлэх материал

Судалгааны хамрах хүрээ	Улаанбаатар хот
Судалгаанд хамрагдагч	<ul style="list-style-type: none"> • Иргэн, аж ахуйн нэгж эрхлэгч, бодлого тодорхойлогч, сэтгүүлч, оюутан, багш
Түүврийн хэмжээ	<ul style="list-style-type: none"> • 2,000
Давтамж	<ul style="list-style-type: none"> • 1 удаа
Судалгааг гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none"> • 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдөр
Гүйцэтгэх ажил, хүлээгдэх үр дүн	Төв банкны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцааг үнэлдэг шилдэг аргачлалын дагуу судалгаанд хамрагдагчдаас түүвэр судалгаа авч, үр дүнг нэгтгэх
Бүрдүүлэх материал	<p>Мэдүүлгээ ирүүлж буй судалгааны баг, байгууллага нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах материалыг ирүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Судалгаа, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг туршлагатай, судалгааны чиглэлээр томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байсан тухай танилцуулга; • Судалгаа, шинжилгээ хийх, тайлан дүгнэлт боловсруулах чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний танилцуулга /2 нүүрээс хэтрэхгүй/; • Судалгаа хийх аргачлал, түүний давуу талын талаарх танилцуулга; • Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх ажлын хуваарь болон үнийн дэлгэрэнгүй санал.

Судалгааны ажлын талаарх нэмэлт мэдээллийг 2016.11.02-ны өдрөөс 2016.11.10-ны өдрийн 09:30-17:00 цагийн хооронд Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвийн 312939 утсаар авч болно. Материалаа дор дурдсан хаягаар **2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 17:00 цагийн дотор** ирүүлнэ үү.

Хаяг:

Монголбанк, Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв.
Бага тойруу 3, 15160 Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг